

**ӨРХИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ  
2013 ОНЫ 4-Р УЛИРЛЫН ҮР ДҮН**

Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгаагаар ядуурлын үзүүлэлтүүдийг бүс, улсын түвшинд мөн суурьшлаар тооцон гаргаж байна.

Ядуурал, амьжиргааны үзүүлэлтүүдийг аймаг, нийслэл, бүс, улсын түвшнээр тооцон гаргах нь улс орны хөгжлийн төлөвлөлт, төрөөс хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг үнэлэхэд чухал ач холбогдолтой болно.

2013 оны 4 дүгээр улиралд Улаангом, Наранбулаг, Түргэн, Бөхмөрөн сумдын 102 өрхийг судалгаанд хамрууллаа.

Өрхийн нийгэм эдийн засгийн 2013 оны 4 дүгээр улирлын судалгааны дүнгээр аймгуудын төвийн дунджаар нэг өрхийн сарын дундаж орлого 942.7 мян.төгрөг, сумын төвийн өрхүүдийнх дунджаар 795.8, хөдөөгийн өрхүүдийнх 758.8 мян.төгрөг байна. Баруун бүсийн нэг өрхийн сарын дундаж орлого 914.8 мянган төгрөг байгаа нь хангай, зүүн бүсүүдээс 77.6 - 174.6 мянган төгрөгөөр өндөр, төвийн бүс болон Улаанбаатар хотоос 4.2 – 229.8 мянган төгрөгөөр бага байна.

Аймгийн төвийн нэг өрхийн дундаж орлогын 95.1 хувь, сумын төвийн өрхийн 85.0, хөдөөгийн өрхүүдийн 72.1 хувь нь цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, МАА, газар тариалангийн бүтээгдэхүүний орлого, бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого гэх мэтээр мөнгөн орлогоос бүрдэж байна.

Нэг өрхийн сарын дундаж орлогод эзлэх мөнгөн орлогын хувь 91.6 хувь буюу өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.

**НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО**, эх үүсвэр, байршлаар, 2013 оны 4 дугаар улирлын байдлаар

| Орлогын төрөл   | төгрөг          |                  |                 |                 |                 |
|---|-----------------|------------------|-----------------|-----------------|-----------------|
|   | улсын дундаж    | нийслэл          | аймгийн төв     | сумын төв       | хөдөө           |
| <b>Орлого бүгд</b>  | <b>975423.3</b> | <b>1144632.4</b> | <b>942680.3</b> | <b>795796.4</b> | <b>758832.5</b> |
| <b>1.Мөнгөн орлого бүгд</b>   | <b>893501.9</b> | <b>1112246.6</b> | <b>896099.8</b> | <b>676742.3</b> | <b>574337.3</b> |
| Цалин хөлс  | 474367.5        | 682899.0         | 477908.9        | 347745.7        | 75146.4         |
| Тэтгэвэр тэтгэмж, нөхөн олговор                                     | 144651.8        | 166548.8         | 146779.8        | 121837.4        | 108742.2        |
| Мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого                                   | 71002           | 1834.3           | 19717.4         | 71926.8         | 297468.0        |
| Газар тариалангийн үйлдвэрийн орлого                                | 2501            | 851.9            | 4059.1          | 5060.1          | 2462.3          |
| Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого                  | 101733.4        | 136609.7         | 126576.9        | 77227.2         | 9160.1          |
| Бусад орлого  | 99246.2         | 123502.9         | 121057.7        | 52945.1         | 54358.3         |
| <b>2. Бусдаад үнэгүй авсан хүнс болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>  | <b>34000.9</b>  | <b>28784.8</b>   | <b>32997.5</b>  | <b>46614.8</b>  | <b>37043.8</b>  |
| <b>3. Өөрийн хувийн аж ахуйшаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b> | <b>47920.5</b>  | <b>3601.0</b>    | <b>13583.0</b>  | <b>72439.3</b>  | <b>174451.4</b> |

**НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ**, эх үүсвэр, байршлаар, 2013 оны 4 дугаар улирлын байдлаар

| Орлогын төрөл   | хувь         |              |              |              |              |
|---|--------------|--------------|--------------|--------------|--------------|
|   | улсын дундаж | нийслэл      | аймгийн төв  | сумын төв    | хөдөө        |
| <b>Орлого бүгд</b>  | <b>100.0</b> | <b>100.0</b> | <b>100.0</b> | <b>100.0</b> | <b>100.0</b> |
| <b>1.Мөнгөн орлого бүгд</b>   | <b>91.6</b>  | <b>97.2</b>  | <b>95.1</b>  | <b>85.0</b>  | <b>72.1</b>  |
| Цалин хөлс  | 48.6         | 59.7         | 50.7         | 43.7         | 9.9          |
| Тэтгэвэр тэтгэмж, нөхөн олговор                                     | 14.8         | 14.5         | 15.6         | 15.3         | 14.3         |
| Мал аж ахуйн үйлдвэрлэлийн орлого                                   | 7.3          | 0.2          | 2.1          | 9.0          | 39.2         |
| Газар тариалангийн үйлдвэрийн орлого                                | 0.3          | 0.1          | 0.4          | 0.6          | 0.3          |
| Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого                  | 10.4         | 11.9         | 13.4         | 9.7          | 1.2          |
| Бусад орлого  | 10.2         | 10.8         | 12.9         | 6.7          | 7.2          |
| <b>2. Бусдаад үнэгүй авсан хүнс болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>  | <b>3.5</b>   | <b>2.5</b>   | <b>3.5</b>   | <b>5.9</b>   | <b>4.9</b>   |
| <b>3. Өөрийн хувийн аж ахуйшаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b> | <b>4.9</b>   | <b>0.3</b>   | <b>1.4</b>   | <b>9.1</b>   | <b>23.0</b>  |

Нэг өрхийн сарын дундаж зарлага 2013 оны 4 дүгээр улиралд аймгуудын төвүүдийн дунджаар 952.6 мян.төгрөг, сумын төвийн өрхүүдийн дунджаар 801.1 хөдөөгийн өрхүүдийнх 824.1 мян.төгрөг байна.

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, зарлагын төрөл, байршлаар, 2013 оны 4 дүгээр улирлын байдлаар

| Зарлагын төрөл  | төгрөг          |                  |                 |                 |                 |
|---|-----------------|------------------|-----------------|-----------------|-----------------|
|   | улсын дундаж    | нийслэл          | аймгийн төв     | сумын төв       | хөдөө           |
| <b>Зарлага бүгд</b>   | <b>984415.2</b> | <b>1131112.4</b> | <b>952609.4</b> | <b>801117.7</b> | <b>824092.5</b> |
| <b>1. Мөнгөн зарлага бүгд</b>                                       | <b>902493.8</b> | <b>1098726.6</b> | <b>906028.9</b> | <b>682063.6</b> | <b>612597.3</b> |
| Хүнсний бүтээгдэхүүний зарлага                                      | 220464.2        | 289009.8         | 223132.4        | 167025.4        | 97499.0         |
| Хүнсний бус бараа , үйлчилгээний зарлага                            | 564505.4        | 685724.3         | 557116.5        | 412078.9        | 410540.0        |
| Бусад зарлага   | 93080.3         | 101150.8         | 102723.2        | 75394.7         | 77265.9         |
| Бусдад өгсөн бэлэг, тусламж   | 24443.9         | 22841.7          | 23056.8         | 27564.6         | 27292.4         |
| <b>2. Бусдаас үнэгүй авсан хүнс болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>  | <b>34000.9</b>  | <b>28784.8</b>   | <b>32997.5</b>  | <b>46614.8</b>  | <b>37043.8</b>  |
| <b>3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b> | <b>47920.5</b>  | <b>3601.0</b>    | <b>13583.0</b>  | <b>72439.3</b>  | <b>174451.4</b> |

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, зарлагын төрөл, байршлаар, 2013 оны 4 дугаар улирлын байдлаар

| Зарлагын төрөл  | хувь         |             |             |             |             |
|---|--------------|-------------|-------------|-------------|-------------|
|   | улсын дундаж | нийслэл     | аймгийн төв | сумын төв   | хөдөө       |
| <b>Зарлага бүгд</b>   | <b>100</b>   | <b>100</b>  | <b>100</b>  | <b>100</b>  | <b>100</b>  |
| <b>1. Мөнгөн зарлага бүгд</b>                                       | <b>91.7</b>  | <b>97.1</b> | <b>95.1</b> | <b>85.1</b> | <b>74.3</b> |
| Хүнсний бүтээгдэхүүний зарлага                                      | 22.4         | 25.6        | 23.4        | 20.9        | 11.8        |
| Хүнсний бус бараа , үйлчилгээний зарлага                            | 57.3         | 60.6        | 58.5        | 51.4        | 49.8        |
| Бусад зарлага   | 9.5          | 8.9         | 10.8        | 9.4         | 9.4         |
| Бусдад өгсөн бэлэг, тусламж   | 2.5          | 2           | 2.4         | 3.4         | 3.3         |
| <b>2. Бусдаас үнэгүй авсан хүнс болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>  | <b>3.4</b>   | <b>2.6</b>  | <b>3.5</b>  | <b>5.8</b>  | <b>4.5</b>  |
| <b>3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b> | <b>4.9</b>   | <b>0.3</b>  | <b>1.4</b>  | <b>9.1</b>  | <b>21.2</b> |

2013 оны 4 дугаар улирлын байдлаар нэг өрхийн сарын дундаж зарлагын 91.7 хувийг мөнгөн зарлага, 3.4 хувийг бусдаас үнэгүй авсан хүнс болон хүнсний бус бүтээгдэхүүн, 4.9 хувийг өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний зүйлийн зарлага эзэлж байна.

Нэг өрхийн сарын дундаж зарлагын 91.7 хувийг мөнгөн зарлага эзэлж байгаа бөгөөд үүний 22.4 хувийг хүнсний бүтээгдэхүүний зарлага, 66.8 хувийг хүнсний бус бараа үйлчилгээний болон бусад зарлага эзэлж хүнсний зарлагын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр буурсан байна.

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ, улсын дунджаар, 2013 оны 4 дугаар улирлын байдлаар

| Орлогын төрөл  | хувь        |             |             |             |             |
|--|-------------|-------------|-------------|-------------|-------------|
|  | 2012        | 2013        |             |             |             |
|  | X-XII       | I-III       | IV-VI       | VII-IX      | X-XII       |
| <b>Орлого Бүгд</b>   | <b>100</b>  | <b>100</b>  | <b>100</b>  | <b>100</b>  | <b>100</b>  |
| <b>1. Мөнгөн орлого бүгд</b>                                       | <b>91.6</b> | <b>90.4</b> | <b>89.4</b> | <b>91.2</b> | <b>91.6</b> |
| Цалин хөлс   | 45.9        | 41.7        | 44.6        | 47.7        | 48.6        |
| Тэтгэвэр тэтгэмж, нөхөн олговор                                    | 19.1        | 18.7        | 15.9        | 15.1        | 14.8        |
| Хувийн аж ахуйн орлого   | 18.9        | 19.4        | 19.4        | 18.1        | 18.0        |
| Бусад  | 7.7         | 10.6        | 9.5         | 10.3        | 10.2        |
| <b>2. Бусдаас үнэгүй авсан хүнс болон хүнсний бус бүтээгдэхүүн</b> | <b>3.3</b>  | <b>3.8</b>  | <b>3.7</b>  | <b>3.3</b>  | <b>3.5</b>  |
| <b>3. Өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>       | <b>5.1</b>  | <b>5.8</b>  | <b>6.9</b>  | <b>5.5</b>  | <b>4.9</b>  |

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, улсын дунджаар, 2013 оны 4 дугаар улирлын байдлаар

| Зарлагын төрөл  | хувь        |             |             |             |             |
|---|-------------|-------------|-------------|-------------|-------------|
|   | 2012        | 2013        |             |             |             |
|   | X-XII       | I-III       | IV-VI       | VII-IX      | X-XII       |
| <b>Зарлага Бүгд</b>   | <b>100</b>  | <b>100</b>  | <b>100</b>  | <b>100</b>  | <b>100</b>  |
| <b>1. Мөнгөн зарлага бүгд</b>                                     | <b>91.1</b> | <b>89.6</b> | <b>88.6</b> | <b>90.9</b> | <b>91.7</b> |
| Хүнсний бүтээгдэхүүний зарлага                                    | 24.7        | 24.9        | 23.9        | 23.5        | 22.4        |
| Хүнсний бус бараа , үйлчилгээний болон бусад зарлага              | 64.7        | 61.7        | 62.4        | 65.2        | 66.8        |
| Бусдад өгсөн бэлэг, тусламж                                       | 1.7         | 3.0         | 2.3         | 2.2         | 2.5         |
| <b>2. Бусдаас үнэгүй авсан хүнс болон хүсний бус бүтээгдэхүүн</b> | <b>3.5</b>  | <b>4.1</b>  | <b>4</b>    | <b>3.4</b>  | <b>3.4</b>  |
| <b>3. Өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>      | <b>5.4</b>  | <b>6.3</b>  | <b>7.4</b>  | <b>5.7</b>  | <b>4.9</b>  |

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, өрхийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, хот, хөдөөгөөр, бүсээр, суурьшлаар, 2013 оны 3 дугаар улирлын байдлаар

|                     | төгрөг      |                              |   |
|---------------------|-------------|------------------------------|---|
|                     | нийт өрхөөр | цалинтай ажил эрхэлдэг өрх * | ХАА-н бус үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг өрх |
| <b>Улсын дундаж</b> | 975423.3    | 1118924.0                    | 1330163.0                                   |
| Хот                 | 1078230.0   | 1186683.0                    | 1366084.0                                   |
| Хөдөө               | 775808.8    | 876696.3                     | 1179888.0                                   |
| <b>Бүс</b>          |             |                              |   |
| Баруун              | 914797.3    | 1085145.0                    | 1312856.0                                   |
| Хангай              | 740171.0    | 918562.8                     | 1275915.0                                   |
| Төв                 | 918969.5    | 1024182.0                    | 1194287.0                                   |
| Зүүн                | 837157.0    | 853392.5                     | 1013953.0                                   |
| Улаанбаатар         | 1144632.4   | 1241459.0                    | 1420129.0                                   |
| <b>Суурьшил</b>     |             |                              |   |
| Улаанбаатар         | 1144632.4   | 1241459.0                    | 1420129.0                                   |
| Аймгийн төв         | 942680.3    | 1066175.0                    | 1277433.0                                   |
| Сумын төв           | 795796.4    | 911307.6                     | 1231204.0                                   |
| Хөдөө               | 758832.5    | 786034.8                     | 964722.3                                    |

Баруун бүсийн өрхүүдээс өрхийн аль нэг гишүүн нь цалинтай ажил эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого 1085.1 мянган төгрөг, ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого 1312.9 мянган төгрөг байгаа нь цалинтай ажил эрхэлдэг хүнтэй, ХАА—н бус үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн тухайд Улаанбаатар хотын дунджаас бага байгаа бол бусад бүсүүдээс өндөр байна.